

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2024 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН “САРЫН МЭДЭЭ”

Барилга, хот байгуулалтын хэлтэс захиалагчийн хяналт

2024 оны 09 сарын байдлаар улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа нийт 10 ажилд захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж 8 объектод шаардлагатай арга хэмжээг авах, ажлыг гэрээт хугацаанд гүйцэтгэх, холбогдох норм дүрмийн хэрэгжилтийг хангах зэрэг үүрэг даалгавар өгч, албан бичгээр хүргүүлэн ажиллаж байна.



Барилга байгууламжид ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрлийг нийт 14 объектод олгосон, байнгын ашиглалтад оруулах ажлын хүрээнд 09 дүгээр сард Шивээговь сумын 3-р цэцэрлэгийн 150 ортой хүүхдийн өргөтгөлийн барилгын ажилд 2024.09.19-д улсын комисс ажилласан.

